



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020.02.04

№ ТУЗ2020001

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ДҮГНЭХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 02 сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХОЁР. Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ГУРАВ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуунд даалгасугай.

ДӨРӨВ. Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Алтайн зам ХК / Б.Энхбат, Э.Өлзийхутаг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020.02.04

№ ТУЗ2020002

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 сарын 04-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2020 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

ХОЁР. Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА